

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавар нийт 76 оноотой. Даалгавар бүр 5 сонгох хариулттай бөгөөд зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай. Амжилт хүсье.

1. Адилтгах замаар зөв хариултыг сонгоно уу. (1 оноо)

a. 5–1 сая жилийн өмнө - Австролопитек

b. 800.000 жилийн өмнө – Монголд?

A. Неандерталь

B. Хомо сапиенс сапиенс

C. Хомо хабилис

D. Хомо эректус

E. Хомо сапиенс

2. Эртний хүмүүсийн амьдралд гарсан дэвшил, ололтыг чулуун зэвсгийн үечлэлээр нь эхлэлээс төгсгөл рүү зөв эрэмбэлсэн хариултыг олно уу. (2 оноо)

1. Нум сум

2. Хэл яриа

3. Гал

A. 1, 2, 3

B. 3, 2, 1

C. 2, 1, 3

D. 3, 1, 2

E. 2, 3, 1

3. Неолитын үеийн Монгол нутагт оршин суугчдын дунд гар урлал шинэ шатанд хөгжсөнийг юугаар нотолдог вэ? (1 оноо)

A. Хүрэл зэвсэг

B. Шавар ваар

C. Хадны зураг

D. Ширмэл ширдэг

E. Төмөрлөг зэвсэг

4. НТӨ XIII-IV зуунд холбогдох Монгол орны төв болон зүүн хэсгээр тархсан нүүдэлчдийн дурсгал аль нь вэ? (1 оноо)

A. Буган хөшөө

B. Хиргисүүр

C. Дөрвөлжин булш

D. Түүвэр олдвор

E. Чандманы соёл

5. НТӨ 1792 онд Месопотамийг эзэлж, Вавилон улсыг үндэслэн байгуулсан хаан хэн бэ? (1 оноо)

A. Ашурбанипал

B. I Саргон

C. Навуходоносор

D. Хаммурапи

E. II Саргон

6. Он тооллын шугамыг анхааралтай ажиглан, доорх асуултад тохирох хариултыг сонгоно уу. (2 оноо)



a. Эртний Египет хэдэн жил оршин тогтносон бэ?

b. Эртний Египет хэдээс хэддүгээр зуунд оршин тогтнож байсан бэ?

A. a. 1569 жил, b. НТӨ XXVIII-XXI зуун

B. a. 4960 жил, b. НТӨ XXIX- IV зуун

C. a. 4925 жил, b. НТӨ XVI-XI зуун

D. a. 810 жил, b. НТӨ XXI- XI зуун

E. a. 840 жил, b. НТӨ XXIX-XXI зуун



7. Хүснэгтийг ажиглан эртний Энэтхэг улсад холбогдох зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)

1. Газар нутаг	2. Түүхэн зүтгэлтэн	3. Улс
a. Нил мөрөн	a. Канишка	a. Аккадын хаант улс
b. Ганга мөрөн	b. Нармер	b. Кушан улс
c. Евфрат мөрөн	c. Сенусерт	c. Ся улс

A. 1b, 2a, 3a B. 1b, 2a, 3b C. 1a, 2a, 3c D. 1b, 2a, 3c E. 1b, 2c, 3a

8. “Ин Жэн хуанди, шавар арми, жин хэмжүүр” хэмээх ойлголтууд нь эртний Хятадын ямар улсад холбогдох вэ? (1 оноо)

A. Жоу B. Шан C. Цинь D. Ся E. Хан

9. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу. (1 оноо)

Эртний Грекийн иргэншил нь Эгейн тэнгис дэх хойгийн баруун, зүүн өмнөд талд олон тооны аралд (1400 орчим) бүрэлдэн тогтжээ.

A. Солонгосын B. Аппениний C. Скандинавын D. Балканы E. Энэтхэг, Хятадын

10. Эртний Ромын түүхэнд холбогдох үйл явдлуудыг он цагийн зөв дараалалд оруулсныг сонгоно уу. (2 оноо)

1. Пунийн дайн болов.
2. Ромын анхны бичмэл “12 самбарын хууль”-ийг батлав.
3. Баруун Ромын эзэнт улс мөхөв.


A. 2, 1, 3 B. 3, 2, 1 C. 1, 2, 3 D. 2, 3, 1 E. 3, 1, 2

11. Хүннү гүрний өмнөд хил хязгаар хаана хүрч байсан бэ? (1 оноо)

A. Дорнод Туркестан B. Хянганы нуруу C. Байгал нуур D. Алтайн нуруу E. Цагаан хэрэм

12. Он тооллын шугамыг ашиглан зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)

Энэ жил “Үндэсний их баяр наадам”-аар Монголын тулгар төр байгуулагдсаны хэдэн жилийн ой болох вэ?




A. 1816 жил B. 2234 жил C. 302 жил D. 2118 жил E. 819 жил

13. Киргизүүдийг шахан гаргаснаар Монгол нутагт түрэг угсаатны ноёрхлыг халж улмаар 842-923 он хүртэлх үеийг “Татаруудын үе” хэмээн нэрлэдэг. Энэхүү түүхэн цаг хугацаа нь хэддүгээр мянганд хамаарах вэ? (1 оноо)

A. I мянганы II хагас B. II мянганы I хагас C. I мянганы I хагас
D. II мянганы II хагас E. III мянганы I хагас



14. Монгол нутагт байгуулагдсан эртний төрт улсын он тооллын шугамыг анхааралтай ажиглан, доорх асуултад тохирох хариултыг сонгоно уу. (2 оноо)



а. Ямар угсааны улс бэ?

б. Хэн байгуулсан бэ?

- A. а. Монгол, б. Амбагян В. а. Монгол, б. Чарагуй С. а. Түрэг, б. Буман
D. а. Түрэг, б. Пэйло Е. а. Монгол, б. Таньшихуай

15. Ноёны уулын язгууртны булшнаас ширмэл ширдэг олджээ. Энэхүү олдвор нь эртний ямар улсын түүхэнд холбогдох вэ? (1 оноо)

- A. Хүннү В. Сяньби С. Жужан D. Түрэг Е. Уйгур

16. Монгол нутаг дахь эртний улсуудын аж ахуй, соёлын ололтуудаас Түрэг улсын үед хамаарах зөв хариултыг сонгоно уу. (1 оноо)

1. Их, бага бичиг

2. Руни бичиг

3. Төмөр дөрөө

4. Культегины хөшөө

5. Тариалангийн хууль

- A. 1, 2 В. 2, 4 С. 3, 5 D. 2, 3 Е. 1, 5

17. Франк улсын хаадаас 50 гаруй удаагийн аян дайн хийж, Баруун Ромын эзэнт улстай эн тэнцэхүйц хүчирхэг болгосон хаан хэн бэ? (1 оноо)

- A. Немец Людвиг В. Хлодвиг С. Их Карл D. Намхан Пипин Е. Карл Мартелл

18. Доорх сурвалжийн мэдээ нь дундад зууны өрнө дахины ямар улсын тухай өгүүлж байна вэ? (2 оноо)

“Жил бүр Христийн мэндэлсэн өдөр хааны зарлигаар тэнд их үзвэр зохион байгуулагдаж, хаан хатанд зориулан тоглолт хийж, олон хүн оролцон, арслан, барс, баавгай, луус заримдаа шувуудын тоглолт үзнэ”/ 1117 оны 12 сард Константинополь хотод айлчилсан Туделийн Вениаминий тэмдэглэлээс/

- A. Орос улс В. Франк улс С. Византын эзэнт улс D. Вандал улс Е. Зүүн Гот улс

19. Бүдүүвчийг ажиглан баруун славянд хамаарах өнөөгийн улсыг сонгоно уу. (1 оноо)



- A. Словак В. Польш С. Орос D. Беларусь Е. Чех



20. Дундад зууны үеийн Майя, Ацтек, Инк зэрэг улсуудтай холбогдох **a, b** жагсаалтыг ямар шалгуураар гаргасан бэ? (2 оноо)

a. Юкатаны хойг, одоогийн Мексик, Андын нуруу

b. Нарны хуанли, одон орон, бичиг үсэг, сургууль

- A. a. Газар нутаг, b. ач холбогдол B. a. Нийслэл хот, b. аж ахуй
C. a. Газар нутаг, b. соёлын ололт D. a. Байгаль газар зүй, b. шашин
E. a. Эх сурвалж, b. соёлын хөгжил

21. Мэдээллийг уншиж, тохирох түлхүүр үгийг сонгоно уу. (2 оноо)

845 онд Ву Зон хааны зарлигаар (1)шашны 4600 сүм хийдийг буулгаж, 250.000 ламыг хүчээр хар болгосон байна. Х зууны эхний хагаст Хятадад (2) гаргаж сурчээ. Европт үүнээс 300 жилийн дараа хэрэглэж эхэлсэн юм. Хятад орон дахин задарч жанжин Жао Куанжин 960 онд Хятадын нэгдмэл байдлыг сэргээн(3).....ыг байгуулжээ.

1	2	3
a. Шинто	a. Шаазан урлал	a. Сүн улс
b. Загалмайн	b. Дарь	b. Тан улс
c. Бурхны	c. Торго	c. Сүй улс

- A. 1b, 2a, 3c B. 1c, 2b, 3a C. 1b, 2c, 3a D. 1c, 2a, 3b E. 1a, 2b, 3c

22. Энэтхэг улсын кастын тогтолцооны нийгмийн давхрааг зөв тохируулна уу. (1 оноо)

1. Брахман a. Тариачид, урчууд, худалдаачид
2. Шудра b. Цэргийн жанжид, язгууртнууд
3. Вашяа c. Газаргүй тариачид, боолууд
4. Кшатра d. Санваартнууд

- A. 1b, 2c, 3d, 4a B. 1d, 2c, 3a, 4b C. 1b, 2c, 3a, 4d
D. 1d, 2c, 3b, 4a E. 1d, 2b, 3a, 4c

23. Адилтгах замаар зөв хариултыг сонгоно уу. (1 оноо)

a. Бурхны зам – Шинто

b. Мандах нарны орон - ?


- A. Ниппон B. Хирагана C. Харакири D. Катакана E. Самурай

24. Дарлигин овог хаана үүссэн бэ? (1 оноо)

- A. Бурхан халдунд B. Гурван голын эхэнд C. Эргүнэ гүнд
D. Буйр нуурын сав газар E. Хэрлэн голын савд



25. XII зууны газрын зурагт Хэрэйд улсын газар нутгийг ямар тоогоор тэмдэглэсэн байна вэ?
(2 оноо)



A. 3 B. 1 C. 4 D. 2 E. 5

26. Цэргийн жанждаас **Боорчу, Мухали, Борохул, Чулуун** нарыг Чингис хаан хэрхэн онцгойлон үнэлж нэрлэсэн бэ? (1 оноо)

A. Төрийн бэхи B. Дөрвөн нохос C. Дархан D. Дөрвөн хүлэг E. Түмтийн ноёд

27. Чингис хааны Монголын түүхэнд гүйцэтгэсэн үүргийг зөв ялгасан хэсгийг сонгоно уу.
(1 оноо)

- Их Монгол улсыг байгуулав.
- Евразийг дамнасан газар нутагт нэгдсэн дэг журам тогтоов.
- Өрнө, дорнын улсуудын хооронд худалдаа, соёлын харилцаа хөгжив.
- Хархорум хотыг байгуулах зарлиг буулгав.

A. 2, 4 B. 1, 2 C. 3, 4 D. 2, 3 E. 1, 4

28. 1236 оноос эхэлсэн Зүүн Европыг байлдан дагуулах зорилготой аян дайныг түүхэнд “Ахмад хөвгүүдийн аян дайн” гэж нэрлэдэг. Уг үйл явдал нь Чингисийн тооллын хэдэн онд болсон бэ? (1 оноо)

A. Чингисийн 47 он B. Чингисийн 74 он C. Чингисийн 30 он
D. Чингисийн 75 он E. Чингисийн 73 он

29. Өнөөгийн Монгол, Хятад, Солонгос, Өмнөд Азийн нутаг дэвсгэрийг нэгтгэн захирч байсан Монголын эзэнт гүрэн аль нь вэ? (1 оноо)

A. Их Монгол улс B. Цагадайн улс C. Ил хаант улс
D. Алтан Ордны улс E. Их Юань улс



30. Хүснэгтийг ажиглан Ил хаант улсад холбогдох зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)

1. Түүхэн зүтгэлтэн	2. Он цаг	3. Соёлын ололт
a. Хүлэгү	a. 1271 он	a. Судрын чуулган
b. Бат	b. 1242 он	b. Кебек хааны зоос
c. Хубилай	c. 1221 он	c. Дөрвөлжин бичиг
d. Цагадай	d. 1256 он	d. Абдулла ноёны гэрэгэ

A. 1b, 2d, 3a B. 1a, 2d, 3a C. 1a, 2a, 3d D. 1c, 2b, 3c E. 1d, 2c, 3b

31. 1368 онд Монголын улс төрийн төв эх нутагтаа төвлөрснөөр Хятадад ямар улс байгуулагдсан бэ? (1 оноо)

A. Орос B. Төвөд C. Киргиз D. Мин E. Чусон

32. Дорнод Монголын зүүн гурван түмнийг зөв сонгоно уу. (1 оноо)

A. Дөрвөд, Хошууд, Цорос B. Халх, Ордос, Цахар C. Цахар, Урианхай, Түмэд
D. Халх, Цахар, Урианхай E. Халх, Ордос, Урианхай

33. XVII зууны Монголын бие даасан улсуудаас **1691 он, Эрдэнэ зуу, Гэрсэнз** зэрэг ойлголтууд нь аль улсад холбогдох вэ? (1 оноо)

A. Өвөр Монгол B. Халх Монгол C. Зүүнгар улс
D. Хошууд улс E. Хотгойд улс

34. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу. (2 оноо)

1. Өвөр Монгол a. Баруун гар Засагт хан, Зүүн гар нь Түшээт хан, Сэцэн хан аймаг
2. Халх Монгол b. Цорос, Хошууд, Дөрвөд, Торгууд
3. Ойрад Монгол c. Хорчин, Жарууд, Баарин, Түмэд, Харчин

A. 1c, 2b, 3a B. 1b, 2a, 3c C. 1b, 2c, 3a D. 1c, 2a, 3b E. 1a, 2b, 3c

35. XVII зууны үед монгол бичгийг ярианы хэлтэй ойртуулах, Төвд ба санскрит үгийг хялбар бичих зорилгоор хэн, ямар үсгийг зохиосон бэ? (1 оноо)

A. Аюуш гүүш, али гали B. Намхайжамц, тод C. Занабазар, соёмбо
D. Пагва лам, дөрвөлжин бичиг E. Агваандорж, вагиндра

36. XIV-XVII зууны Монголын түүхийн сурвалж бичгүүдэд аль нь хамаарах вэ? (1 оноо)

1. Эрдэнийн товч 2. Монголын нууц товчоо 3. Лу.Алтан товч
4. Жангар 5. Убаши хунтайжийн тууж

A. 4, 5 B. 1, 2 C. 1, 3 D. 3, 4 E. 1, 5

37. Лигдэн хаан нас барснаар 1636 онд Өвөр Монголын ноёд чуулган хийж хаана, хэнд дагаар орсон бэ? (1 оноо)

A. Бээжинд, Нурхач B. Долоон нуурт, Энх-Амгалан C. Цахарт, Лигдэн
D. Мүгдэнтд, Абахай E. Ар элстэйд, Занабазар



38. Халимаг, Буриадын түүхэнд холбогдох үйл явдлуудыг он цагийн хувьд зөв дараалалд оруулсныг сонгоно уу. (1 оноо)

1. Буурын гэрээ байгуулав.

2. Халимаг–Орос цэргийн холбооны гэрээ байгуулав.

3. Халимагийн сүүлчийн их нүүдэл болов.

A. 2, 3, 1

B. 3, 2, 1

C. 2, 1, 3

D. 1, 3, 2

E. 1, 2, 3

39. Дайчин төрөөр нэгтгэх бодлогыг ямар хаан хэрэгжүүлж байсан бэ? (1 оноо)

A. Лигдэн хутагт хаан

B. Галдан бошогт хаан

C. Түмэн засагт хаан

D. Батмөнх даян хаан

E. Түмэдийн Алтан хан

40. Монголчууд харийн эрхшээлд ороход нөлөөлсөн дотоод шалтгаан аль нь вэ? (1 оноо)

A. Мин улсын хагалан бутаргах, бодлого нөлөөлсөн.

B. Манж улс хагалан бутаргах, эзлэн түрэмгийлэх бодлогоо явуулсан.

C. Монголын их хааны сүр хүч буурч, төвлөрсөн засаглал суларсан.

D. Манж улс Монголчуудыг их цэргээр удаа дараа довтолсон.

E. Хаант Орос улс газар нутгаа тэлэх бодлого явуулж байсан.

41. 1858, 1905–1907 онуудад Ордост 300-800 орчим хүнийг хамарсан эсэргүүцэл гарчээ.

Энэхүү бослого нь тэмцлийн ямар хэлбэрт хамаарах вэ? (1 оноо)

A. Дугуйлангийн хөдөлгөөн

B. Алба хаях

C. Заргын бичиг

D. Зэвсэгт бослого

E. Бөөнөөрөө оргон нүүх

42. Хүснэгтийг ажиглан Сайн ноён аймагт гарсан бослогод холбогдох зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)

1. Түүхэн зүтгэлтэн	2. Он цаг	3. Цэргийн тоо
a. Онолт	a. 1900 он	a. 800
b. Чингүнжав	b. 1880 он	b. 247
c. Ард Аюуш	c. 1755 он	c. 2000

A. 1c, 2b, 3c

B. 1b, 2c, 3a

C. 1a, 2a, 3b

D. 1a, 2b, 3b

E. 1a, 2c, 3b

43. Монголчууд жил бүр “Тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан өдөр”-ийг хэзээ тэмдэглэдэг вэ? (1 оноо)

A. 1-р сарын 13

B. 3-р сарын 18

C. 10-р сарын 27

D. 12-р сарын 29

E. 11-р сарын 26

44. Богд хаант Монгол улсын үеийн **Нийслэл хүрээ 1912, могой цаг** зэрэг ойлголтууд ямар сургуулийг илэрхийлж байна вэ? (1 оноо)

A. Шашны сургууль

B. Цэргийн сургууль

C. Орос хэл бичгийн сургууль

D. Албаны сургууль

E. Иргэний сургууль



45. 1921 онд хувьсгалчид хоорондоо 400-аад нууц түлхүүр үгээр харилцаж байсан бол доорх сурвалжид дурдагдаж буй Георгий гэж хэн бэ? (1 оноо)

“Малын үнэ муу. Хээр морь эмгэгтэй Бутковоос янчаан авах төлөвтэй. Георгийгээр хүргүүлнэ. Мөнгөний явдалд яар. Мөнгөний хариу даруй өг Иван”. Үндэсний Төв Архивын баримтаас

A. Х.Чойбалсан B. Д.Бодоо C. Д.Догсом D. С.Данзан E. Д.Чагдаржав

46. Ардын засгийн газрын үеийн **улс төрийн** арга хэмжээнд хамаарах онцлох үйл явдлуудыг сонгоно уу. (2 оноо)

1. Тангаргийн гэрээг мөрдүүлэв.
2. Бага, дунд сургуулийн танхимын дүрэм батлав.
3. Улсын түр цагийн хурал байгуулав.
4. Үндэсний мөнгөн тэмдэгттэй болох алхам хийгдэв.
5. Судар бичгийн хүрээлэнг байгуулав.

A. 1, 5 B. 2, 4 C. 1, 3 D. 2, 3 E. 4, 5

47. Анхдугаар Үндсэн хуульд зааснаар “Улсын их хурал”-ын чөлөөт цагт ямар байгууллага төрийн эрхтэй байсан бэ? (1 оноо)

A. Ерөнхий сайд B. Засгийн газар C. Улсын бага хурал
D. УИХ-ын тэргүүлэгчид E. Ардын их хурал

48. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу. (1 оноо)

Шинэ эргэлтийн бодлогыг хэрэгжүүлснээр театрын урлагийн хөгжилд гарсан том дэвшил нь 1934 онд жүжгийг төв театрын тайзнаа тоглосон явдал байв.

A. Харанхуй засаг B. Шөнийн буг C. Байцаагч түшмэл
D. Говийн хүүхэн Гүндэгмаа E. Учиртай гурван толгой

49. Өгөгдлийг зөв тохируулна уу. (2 оноо)

- | | |
|-----------------------------|---|
| 1. 1932 оны 6-р сарын 29-30 | a. Аж үйлдвэрийн комбинат байгуулав. |
| 2. 1934 оны 3-р сарын 26 | b. Радио өргөн нэвтрүүлэг явуулж эхлэв. |
| 3. 1934 оны 9-р сарын 1 | c. Шинэ эргэлтийн бодлогыг хэрэгжүүлэв. |

A. 1a, 2b, 3c B. 1c, 2b, 3a C. 1a, 2c, 3b D. 1c, 2a, 3b E. 1b, 2c, 3a

50. Тэгшитгэлийг ашиглаж зөв хариултыг сонгоно уу. (1 оноо)

(Олноо өргөгдсөний 8 он+Ардын хувьсгалын 25 жилийн ой): $2+13=?$

A. 1961 онд Монгол улс НҮБ-д элсэв. B. 1976 онд Атрын II аян өрнөв.
C. 1939 онд Халх голын дайн болов. D. 1945 онд Чөлөөлөх дайн болов.
E. 1959 онд Соёлын довтолгоо өрнөв.




51. МАХН-ын Төв Хорооны тогтоолд “Хүн бүр бага балчраасаа эхлэн туйлын аж ахуйч, арвич хямгач, социалист өмчийн эс ширхэг бүрийг алхам тутамдаа нүдлэн хамгаалагч, хөдөлмөрийг бишрэн шүтэгч байх ёстой” хэмээх сурвалжийн мэдээ нь түүхэн ямар үйл явдлыг илэрхийлж байна вэ? (1 оноо)

- A. Сэхээтний төөрөгдөл B. Намын эсрэг бүлэглэл C. Атрын аян
D. Соёлын довтолгоо E. Нэгдэлжих хөдөлгөөн

52. Ямар түүхэн үйл явдлаар БНМАУ-д олон намын тогтолцоо бий болох эхлэл тавигдсан бэ? (2 оноо)

- A. 1990 оны 3 сарын 22-24-нд хуралдсан АИХ-ын чуулган, МАХН бол “төр нийгмийг удирдан чиглүүлэгч цорын ганц хүчин мөн” гэсэн үндсэн хуулийг заалтыг хүчингүй болгосноор
B. 1990 оны 3 сарын 12-14-нд болсон МАХН-ын бүгд хурлаар улс төрийн товчоо, нарийн бичгийн дарга нарыг бүрэн бүрэлдэхүүнээр огцруулснаар
C. 1990 оны 2 сарын 18-нд Монголын ардчилсан намыг эмхлэн байгуулснаар
D. 1990 оны 3 сарын 7-ны өдрийн 14 цагт МоАХ-ны 10 гишүүн Сүхбаатарын талбайд улс төрийн тэмцлийн хурц хэлбэр болох өлсгөлөн зарлан тэмцсэнээр
E. 1990 оны 3 сарын 9-ний оройн нам төрийн тэргүүн Ж.Батмөнх ард түмэндээ хандан радио телевизээр орон даяар мэдээлэл хийснээр

53. Энэхүү диаграммд хэдэн оны ямар түүхэн үйл явдалтай холбоотой мэдээлэл агуулагдаж байна вэ? (2 оноо)



- A. 1996 оны 6-р сарын 30-нд явагдсан УИХ-ын сонгууль
B. 2000 оны 7-р сарын 3-нд явагдсан УИХ-ын ээлжит сонгууль
C. 1992 оны 6-р сард бүх нийтийн чөлөөт ардчилсан сонгуулийн дүн мэдээ
D. 1990 оны 7-р сарын 22-29-нд явагдсан олон намын ардчилсан сонгууль
E. 1997 оны ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн дүн мэдээ



54. 1990 оны хувьсгалаар оюун санааны хүрээнд гарсан ололтод холбогдох үйл явдлуудыг он цагийн хувьд зөв дараалалд оруулсныг сонгоно уу. (2 оноо)


1. Монголын нууц товчоо зохиогдсоны 750 жилийн ой болов.
2. Монголын төр ард түмнээсээ уучлал гуйж, улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэв.
3. Их монгол улсаа тунхагласны 800 жилийн ойг тэмдэглэв.

A. 1, 3, 2 B. 3, 2, 1 C. 2, 3, 1 D. 1, 2, 3 E. 2, 1, 3

55. Ардчилсан хувьсгалын үр дүнд үндэсний үзэл, ухамсар сэргэснийг зөв илэрхийлсэн нь аль вэ? (2 оноо)

- A. 1993 онд Бурхан багшийн чандрыг Монголд залсан.
- B. Спортын салбарт тив, дэлхийн аваргууд олноор төрсөн.
- C. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль баталсан.
- D. Чингис, Өгэдэй, Хубилай хаадын хөшөөг төрийн ордны өмнө залсан.
- E. Электрон технологи бүтээж, цахим сүлжээ чөлөөтэй ашиглах болсон.

56. Он тооллын шугамыг ажиглан Монгол улсын гадаад харилцааны онцлог үйл явдлын түүхэн зүтгэлтэн, он цагийг зөв сонгоно уу. (2 оноо)



A. 2006, Жорж Буш
D. 2014, Ши Жиньпин

B. 2014, В.Путин
E. 2006, Сергей Лавров

C. 1991, В.Путин



ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай тус бүр 6 оноотой. Нийт 24 оноо
Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.

2.1 Дундад зууны Арабын түүхэнд холбогдох ойлголтуудыг тохируулахдаа 1-7 хүртэлх өгөгдлөөс сонгож зөв харгалзуулна уу. **/1 өгөгдөл илүүг анхаарна уу/** (6 оноо)

- | | |
|----------------------|--|
| a. Мэдлэг, боловсрол | 1. Альгамбрын ордон, Кордова хотын сүм |
| b. Түүхэн зүтгэлтэн | 2. Мусульман, Коран судар |
| c. Хот суурин | 3. Арабын хойг, хойд Африк |
| d. Шашин шүтлэг | 4. Усан үзэм, арвай тариалах |
| e. Аж ахуй | 5. Бичиг үсэг, анагаах ухаан |
| f. Газар нутаг | 6. Абу Бекр, Осман халиф |
| | 7. Медин, Мекка |

2.2 Чингис хаантай холбогдох түүхэн үйл явдлуудыг эхлэлээс төгсгөл рүү он цагаар нь зөв эрэмбэлнэ үү. (6 оноо)

- | | |
|--|-------|
| a. Хэрэйдийн Тоорил хантай эцэг хөвгүүний харилцаа тогтоов | |
| b. Алтан, Хучар, Сача бэхи нар зөвлөлдөж Тэмүжинийг хаанаар өргөмжлөв | |
| c. Наху гүнд Таян ханы цэрэгтэй тулалдаж, Найман улсыг мөхөөв | |
| d. Жамуха Далан Балжудын тулаанд ялалт байгуулав | |
| e. Далан Нөмрөгийн тулаанд Татаруудыг эзлэн мөхөөв | |
| f. Хубилай хааны зарлигаар ордны зураач Хорихосун Чингис хааны хөргийг зурав | |

2.3 БНМАУ-ын нийгэм, эдийн засагт гарсан өөрчлөлтийг холбогдох ойлголттой нь зөв харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|---------------------------|-------------------------------------|
| a. Аж үйлдвэр, дэд бүтэц | 1. Адуучин, хоньчин, саальчин |
| b. Нэгдэлжих хөдөлгөөн | 2. Цахилгаан станц, Эрдэнэт үйлдвэр |
| c. Шинэ эргэлтийн бодлого | 3. Тариаланч, механикжуулагч |
| d. Соёлын довтолгоо | 4. Д.Дамба, Д.Төмөр–Очир, Ц.Лоохууз |
| e. Сэхээтний төөрөгдөл | 5. Бичиг үсэг, ариун цэвэр |
| f. Атрын аян | 6. П.Гэндэн, А.Амар, Х.Чойбалсан |

2.4 БНМАУ-ын боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжилд холбогдох түүхэн зүтгэлтнүүдийг хамаарах үйл явдлуудтай зөв харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|----------------|--|
| a. Д.Чоймбол | 1. Харанхуй засаг жүжгийн зохиолыг бичив |
| b. С.Буяннэмэх | 2. Шинжлэх ухааны академи байгуулав |
| c. Д.Дашдаваа | 3. Монгол хүн сансарт нисэв |
| d. Ж.Мөнхбат | 4. Сүхбаатарын хөшөөг урлав |
| e. Б.Ширэндэв | 5. Малын вакцин бүтээв |
| f. Ж.Гүррагчаа | 6. Олимпоос анхны мөнгөн медалийг хүртэв |

